



GRATA
INTERNATIONAL

МОНГОЛ: УУЛ УУРХАЙ - 2020

GRATA International Mongolia

www.gratanet.com

УУЛ УУРХАЙ – 2020

1. Ерөнхий ойлголт

1.1 Гол онцлог

Монгол Улс ашигт малтмалын асар их нөөцтэй тул уул уурхай болон газрын тосны салбарууд нь хөрөнгө оруулалт эсвэл бизнесийн боломжуудыг эрэлхийлэгч гадаад болон дотоодын компани болон хөрөнгө оруулагч нарын анхаарлыг ихээр татдаг.

Олон Улсын Валютын Сангаас тодорхойлсны дагуу Монгол Улс бол уул уурхайн нөөц баялаг ихтэй хөгжиж буй 29 улсуудын нэг юм. Ойролцоогоор 7,076,100 га талбайд 2745 хуулийн этгээд ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрлийг эзэмшиж байгаа бөгөөд энэ нь Монголын нийт нутаг дэвсгэрийн 4,6 хувийг эзэлдэг¹.

Ашигт малтмалын ордыг дараах байдлаар ангилдаг:

- Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын орд;
- Түгээмэл тархацтай ашигт малтмалын орд;болон
- Ердийн ашигт малтмалын орд хэмээн ангилдаг.

1.2 Эрх зүйн тогтолцоо болон эх сурвалж

Монгол Улс нь эх газрын эрх зүйн тогтолцоо болох Ром - Германы эрх зүйн тогтолцоотой. Уул уурхайн салбар 2006 онд батлагдсан Ашигт малтмалын тухай хууль (цаашид **АМтХ** гэх) - иар зохицуулагддаг бөгөөд батлагдсанаасаа хойш хэд хэдэн удаа нэмэлт өөрчлөлт орсон.

АМтХ-ийн дагуу Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам, Тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтын журам, Уурхай, уулын болон баяжуулах үйлдвэрийн нөхөн сэргээлт, хаалтын журам зэрэг журмууд батлагдаж, мөрдөгдөж байна.

¹ <https://www.mrpam.gov.mn/public/pages/165/2020-05-mon.pdf>

Grata International Mongolia

Дэлгэрэнгүй мэдээлэл авах эсвэл асуулт байвал Грата Интернэшнл хуулийн фирмийн Партнер В.Болормаагийн bvolodya@gratanet.com болон Хуульч Б.Янжмаагийн ybumtsend@gratanet.com хаягаар эсвэл 976 70155031 утсаар холбоо барина уу.

АМТХ-иас гадна уул уурхайн салбарыг Газрын тосны тухай хууль, Түгээмэл тархацтай ашигт магтмалын тухай хууль болон Газрын хэвлийн тухай хууль зэрэг бие даасан хуулиад зохицуулдаг.

1.3 Ашигт магтмалын өмчлөл

Монгол Улсын Үндсэн хуулийн 6.2 дугаар зүйлд Монгол Улсын иргэдэд өмчлүүлснээс бусад газар, түүнчлэн газрын хэвлий, түүний баялаг, ой, усны нөөц, ан амьтан төрийн нийтийн өмч мөн хэмээн заасан. Харин АМТХ-ийн дагуу төр өмчлөгчийн хувьд хуульд заасан нөхцөл, шаардлага, журмын дагуу ашигт малтмал хайх, ашиглах тусгай зөвшөөрлийг хуулийн этгээдэд олгох эрхтэй.

Хэрэв эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр хууль бусаар ашигт магтмалын үйл ажиллагаа явуулсан буюу АМТХ-ийг зөрчсөн тохиолдолд Эрүүгийн болон Зөрчлийн хуулиар хариуцлага хүлээнэ.

1.4 Төрийн үүрэг

Төрийн байгууллага шатлан захирах тогтолцооны дагуу Улсын Их Хурал, Засгийн Газар, Уул Уурхай, Хүнд Үйлдвэрийн Яам, Төрийн Захиргааны Байгууллага гэсэн тогтолцоотой².

Улсын Их Хурлын эрх хэмжээ:

- Геологи, уул уурхайн салбарыг хөгжүүлэх талаар төрөөс баримтлах бодлогыг тодорхойлох;
- Засгийн газраас өргөн мэдүүлснээр, эсхүл өөрийн санаачлагаар тухайн ашигт малтмалын ордыг стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордод хамааруулах эсхүл хасах;
- Улсын тусгай хамгаалалттай газарт ашигт малтмал эрэх, хайх, ашиглах асуудлыг шийдвэрлэнэ.

Засгийн газрын эрх хэмжээ:

- Ашигт малтмал эрэх, хайх, ашиглахтай холбогдсон хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах;

² Ашигт магтмалын тухай хууль (2006)

- Улсын тусгай хамгаалалттайгаас бусад тусгай хэрэгцээний газарт ашигт малтмал эрэх, хайх, ашиглах асуудлыг шийдвэрлэх;
- Тодорхой газрыг нөөц болон тусгай хэрэгцээнд авах асуудлыг шийдвэрлэх, эсхүл энэ талаархи саналыг Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ.

Уул Уурхай, Хүнд Үйлдвэрийн Яамны эрх хэмжээ:

- Тусгай зөвшөөрөл авах, хугацааг нь сунгах, шилжүүлэх, тусгай зөвшөөрлөөр олгогдсон талбайг бүхэлд нь, эсхүл тодорхой хэсгийг хүлээлгэн өгөх, хилийн маргааныг шийдвэрлүүлэх, хайгуулын ажлын төлөвлөгөө, мэдээ, тайланг хянуулах ажиллагааны үйлчилгээний хөлсний хэмжээг тогтоох;
- Ашигт малтмал хайх, ашиглах, боловсруулах, борлуулах үйл ажиллагаанд ил тод байдлыг бүрдүүлэх;
- Ашигт малтмал эрэх, хайх, ашиглах үйл ажиллагааны журам батлах, бүтээгдэхүүний стандартыг боловсруулж батлуулна.

Төрийн захиргааны байгууллагын эрх хэмжээ:

- Тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалт зохион явуулах, бичил уурхайн болон түгээмэл тархацтай ашигт малтмалын зориулалтаар талбай олгох дүгнэлт гаргах;
- Уул уурхайн салбарт хөрөнгө оруулалтын таатай орчин бүрдүүлэх, тухайн үед үүссэн нөхцөл байдалд үнэлэлт өгөх;
- Хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй холбоотой үйл ажиллагаанд нэгдсэн хяналт тавих;
- Ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтад оролцох хүсэлтийн өргөдлийг хүлээн авч бүртгэх тус тус эрх хэмжээтэй.

1.5 Ашигт магтмалын тусгай зөвшөөрөл:

Ашигт магтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл, түгээмэл тархацтай ашигт магтмалын зөвшөөрлийг Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу байгуулагдаж үйл ажиллагаа явуулж байгаа татвар төлөгч хуулийн этгээдэд олгодог.

- ✓ "Ашигт малтмал хайх" гэж эрдсийн хуримтлалын байршил, тоо хэмжээг нарийвчлан тогтоох зорилгоор газрын гадаргуу, түүний хэвлийд геологи,

хайгуулын судалгаа хийж, түүний нөөц, баялгийг ашиглах боломжийг судлан техник, эдийн засгийн үнэлгээ хийх;

- ✓ "Ашигт малтмал ашиглах" гэж газрын гадаргуу, түүний хэвлий, хүдрийн овоолго, хаягдал, байгалийн уснаас ашигт малтмал ялган авах, олборлох, түүний ашигт агуулгыг нэмэгдүүлэх, баяжуулах, бүтээгдэхүүн үйлдвэрлэх, борлуулах;
- ✓ "Түгээмэл тархацтай ашигт малтмал" гэж зам, барилгын материалын зориулалтаар ашиглах боломжтой, элбэг тархалт бүхий элс, хайрга, тоосгоны шавар, хүрмэн, боржин, дайрганы зориулалттай барилгын чулууны хуримтлалыг ойлгодог³.

Хүчин төгөлдөр тусгай зөвшөөрөлгүйгээр ашигт магтмал хайх болон ашиглахыг хориглодог бөгөөд нэг тусгай зөвшөөрөл зөвхөн нэг хуулийн этгээдэд олгогддог.

1.6 Ашигт магтмалын тусгай зөвшөөрөл олгох:

- ❖ Уул Уурхай, Хүнд Үйлдвэрийн сайд хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмших хүсэлт ирүүлсэн Өргөдөл гаргагчийн саналыг үнэлэх зорилгоор сонгон шалгаруулалтын комиссыг томилдог. Төрийн Захиргааны Байгууллага сонгон шалгаруулалтын комиссийн дүгнэлтэд үндэслэн хайгуулын тусгай зөвшөөрөл олгодог.
- ❖ Төрийн Захиргааны Байгууллага АМТХ-ийн дагуу уул уурхайн ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмших хүсэлтэй Өргөдөл гаргагчийн ирүүлсэн хүсэлт болон бичиг баримтыг харгалзан үзэж ашиглалтын тусгай зөвшөөрлийг олгоно.
- ❖ Төрийн Захиргааны Байгууллага нь аймаг болон нийслэлийн Засаг даргын шийдвэрийг үндэслэн түгээмэл тархацтай ашигт магтмалын тусгай зөвшөөрлийг олгоно.

1.7 Ашиглалтын аюулгүй байдал

А. Хайгуулын тусгай зөвшөөрөл олгох журам:

Хайгуулын тусгай зөвшөөрөл нь 3 жилийн хугацаатайгаар олгогддог бөгөөд хэрэв тусгай зөвшөөрөл эзэмшигч хүсвэл 3 удаа сунгуулж болдог.

Хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч АМТХ-д заасан нөхцөлийг хэрэгжүүлсний дараа

³ Түгээмэл тархацтай ашигт магтмалын тухай хууль (2014)

хайгуулын талбайг бүхэлд нь эсхүл тодорхой хэсэгт ашиглалтын тусгай зөвшөөрөл авах онцгой эрхтэй. Нэг тусгай зөвшөөрлөөр олгох хайгуулын талбайн хэмжээ 25 гектараас багагүй, 150 мянган гектараас ихгүй байдаг.

Төрийн Захиргааны Байгууллага нь хайгуулын тусгай зөвшөөрлийн сонгон шалгаруулалтын урилгыг үндэсний хэмжээний өдөр тутмын сонин, хэвлэл мэдээллийн бусад хэрэгслээр дамжуулан хуанлийн 30 хоногоос доошгүй хоногийн өмнө албан ёсоор зарладаг. Сонгон шалгаруулалтын зарласан урилгын дагуу хуулийн этгээд үнийн санал болон техникийн саналыг хавсаргасан сонгон шалгаруулалтад оролцох хүсэлтээ илгээдэг.

Техникийн саналд Өргөдөл гаргагч хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар, орон нутаг хөгжүүлэх, хамтран ажиллах санал, мэргэжлийн боловсон хүчин, мэргэшсэн ажилтнаар хангагдсан байдал, төлөвлөгөө зэргийг багтаадаг бол үнийн саналд босго үнэ болон үнийн санал багтдаг. Босго үнэ 2240 төг/га, хэрэв эрдсийн хуримтлал бүхий талбай бол 4480 төг/га байхаар холбогдох журмаар тогтоосон.

Сонгон шалгаруулалтын комисс үнийн санал болон техникийн саналыг үнэлэн дүгнэлт гаргана. 2 болон түүнээс дээш Өргөдөл гаргагч адил үнэлгээ авсан тохиолдолд хамгийн түрүүлж хүсэлт илгээсэн Өргөдөл гаргагч хайгуулын тусгай зөвшөөрлийг эзэмшинэ.

Сонгон шалгаруулалтад шалгараагүй бусад Өргөдөл гаргагчийн төлсөн босго үнийг шалгараагүй үндэслэлийг дурдсан мэдэгдлийг хүргүүлснээс хойш ажлын 5 (тав) өдөрт багтаан буцаан олгоно⁴.

Шалгарсан Өргөдөл гаргагч тусгай зөвшөөрлийн эхний жилийн төлбөр, босго үнийн зөрүү болон санал болгосон үнийг АМТХ-ийн дагуу 10 өдрийн дотор төлсөн тохиолдолд Төрийн Захиргааны Байгууллага 3 жилийн хугацаатайгаар хайгуулын тусгай зөвшөөрлийг олгож, хайгуулын тусгай зөвшөөрлийг бүртгэн талбайг нь зурагзүйн бүртгэлд бүртгэнэ. Хайгуулын тусгай зөвшөөрөл дуусахаас нэг сарын өмнө тусгай зөвшөөрөл эзэмшигч Төрийн Захиргааны Байгууллагад тусгай зөвшөөрлийг сунгуулах хүсэлтээ гаргаж болно.

Б. Ашиглалтын тусгай зөвшөөрөл олгох журам

⁴ Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2018 оны А / 28 дугаар тушаалаар батлагдсан Тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулах журам

Хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч хайгуулын талбайн аль ч хэсэгт ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрлийг эзэмших хүсэлтийг Төрийн Захирагааны Байгууллагад гаргах эрхтэй. Хайгуулын тусгай зөвшөөрөлгүй хуулийн этгээдэд ашиглалтын тусгай зөвшөөрлийг олгохдоо хайгуулын тусгай зөвшөөрөл олгох журмыг баримталдаг.

Төрийн Захиргааны Байгууллага хүсэлтийг хүлээн авахаас татгалзсан шалтгаан эсхүл онцгой эрхийнх нь дагуу ашиглалтын тусгай зөвшөөрөл олгох эсэхийг өргөдлийг бүртгэснээс хойш ажлын 20 өдөрт багтаан шийдвэрлэнэ.

Ашиглалтын тусгай зөвшөөрөл авсан Өргөдөл гаргагч ажлын 20 өдөрт багтаан тусгай зөвшөөрлийн нэг жилийн төлбөрийг төлөх бөгөөд Өргөдөл гаргагч Ашиглалтын тусгай зөвшөөрлийн 1 жилийн төлбөрийн хийснээс хойш 3 хоногийн дотор Төрийн Захирагааны Байгууллага Өргөдөл гаргагчид ашиглалтын тусгай зөвшөөрлийг 30 жилийн хугацаатай олгодог.

Ашиглалтын тусгай зөвшөөрлийн хугацаа дуусахаас 2-оос доошгүй жилийн өмнө ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь Төрийн Захирагааны Байгууллагаас баталсан маягтын дагуу хугацаа сунгуулах тухай өргөдөл гаргаж болно. Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч ашигт малтмалын нөөцийн хэмжээнээс хамааран 20 жилийн хугацаатайгаар 2 удаа тусгай зөвшөөрлөө сунгуулах эрхтэй.

Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь харьяа Байгаль орчны албанаас бичгэн зөвшөөрөл авахгүйгээр хайгуулын болон ашиглалтын үйл ажиллагаа явуулах эрхгүй байдаг.

2. Байгаль орчныг хамгаалах болон хамтын ажиллагаа

2.1 Байгаль орчныг хамгаалах болон тусгай зөвшөөрөл

Байгаль орчныг хамгаалах тухай хууль (БОХТХ) болон АМТХ бол ашигт магтмал ашиглах үйл ажиллагаанд байгаль орчны талаар хүлээсэн үүргүүдээ хэрэгжүүлэх гол хуулиуд юм.

Хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч тусгай зөвшөөрөл авснаас хойш 30 хоногийн дотор Байгаль Орчны Хяналтын Алба болон хайгуулын талбай байрших сум, дүүргийн Засаг даргатай зөвшилцөн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө боловсруулах үүрэг хүлээдэг.

Ашигт магтмалын үйл ажиллагаа эхлэхээс өмнө сонгон шалгаруулалтаар журмаар

ашиглалтын тусгай зөвшөөрөл авсан тусгай зөвшөөрөл эзэмшигч байгаль орчинд нөлөөллийн үнэлгээ хийлгэж, байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулна. Хэрэв тусгай зөвшөөрөл эзэмшигч тусгай зөвшөөрлийн төлбөрийг төлөөгүй, бусдад хууль бусаар шилжүүлсэн, байгаль орчинд хортой нөлөөлж байгаа, эсхүл нөхөн сэргээх, байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд заасан үүргээ биелүүлээгүй тохиолдолд Төрийн Захиргааны Байгууллага эрх хэмжээнийхээ хүрээнд тусгай зөвшөөрлийг цуцлах эрхтэй.

Монгол Улсын Эрүүгийн болон Зөрчлийн тухай хуулийн дагуу АМТХ болон бусад холбогдох хууль зөрчсөн хувь хүн эсхүл хуулийн этгээдийн эрх бүхий албан тушаалтанд торгох, хорих болон эрхийг нь хасах арга хэмжээг авдаг.

2.2 Орон нутаг

Төрийн Захиргааны Байгууллага нь талбайн солбицлыг тодорхойлохдоо тухайн аймаг, нийслэлийн Засаг даргад бичгээр мэдэгдэнэ. Засаг дарга тухайн талбай байрших аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн саналыг авч, 45 хоногийн дотор Төрийн Захиргааны Байгууллагад хариу өгнө. Засаг дарга хуульд заасан үндэслэлээр татгалзсан хариу өгч болно.

Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх асуудлаар нутгийн захиргааны байгууллагатай гэрээ байгуулж ажиллана. Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч болон тэдгээрийн туслан гүйцэтгэгч нь Монгол Улсын иргэдийг ажлын байраар хангах үүрэг хүлээх бөгөөд тухайн хуулийн этгээдэд ажиллагсдын 10-аас дээшгүй хувь нь гадаадын иргэн байж болно.

3. Тогтвортой хөгжил

3.2 Тогтвортой хөгжлийн санаачлагууд

Экологийн талаас авч үзвэл тогтвортой хөгжил нь Монгол улсын байгаль орчны хууль тогтоомжийн гол зарчмуудын нэг. Улсын Их Хурал Тогтвортой хөгжлийг тусгасан Монголын тогтвортой хөгжлийн зорилт -2030 хэмээх урт хугацааны хөгжлийн стратегийг баталсан.⁵ АМТХ нь уул уурхайн ашигт магтмалын үйл ажиллагаа болон байгаль орчин,

⁵ <https://sustainabledevelopment.un.org/memberstates/mongolia>

нийгэм, эдийн засгийн салбарын харилцааг зохицуулдаг. Улсын Их Хурал зах зээлийн хэлбэлзлээс урьдчилан сэргийлэх, тогтвортой хөгжлийг хангах зорилгоор Монгол Улсыг Хөгжүүлэх сангийн тухай хууль баталсан.

4. Татвар

4.1 Татвар болон эрхийн шимтгэл

Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар 10% -аас 25% хооронд байх бөгөөд дараах хувь хэмжээг үндэслэн тогтоодог⁶:

- ✓ 6 тэрбум төгрөг хүртэлх татвар ногдуулах орлого (Монгол банкны ханшаар 2,255,000 ам доллар) – 10 хувь;
- ✓ Татвар ногдуулах жилийн орлого 6.0 тэрбум төгрөгөөс дээш бол 600 сая төгрөг дээр 6.0 тэрбумаас дээш давсан орлогод - 25 хувиар нэмж албан татвар ногдуулна.

Доор дурдсан этгээд ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр төлөгч байна:

- Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч /Олборлож өөрийн хэрэгцээнд ашигласан, дотоодод худалдсан, эсхүл худалдахаар ачуулсан нүүрсний нөөц ашигласны төлбөр борлуулалтын үнэлгээний 2.5 хувь харин бусад ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр тухайн бүтээгдэхүүний борлуулалтын үнэлгээний 5.0 хувь/;
- Ашигт малтмал экспортолсон этгээд / экспортод бүтээгдэхүүн гаргасан бол олон улсын худалдаанд хүлээн зөвшөөрөгдсөн зах зээлийн үнийг баримтлан/;
- Монгол банк, түүнээс эрх олгосон арилжааны банканд алт тушаасан этгээд / Монгол банк, түүнээс эрх олгосон арилжааны банканд худалдсан алтанд ногдох нөөц ашигласны төлбөр борлуулалтын үнэлгээний 5.0 хувь/.

4.2 Татварын урамшуулал

Улсын Их Хурал 2019 онд татварын багц хуулиудыг шинэчлэн баталсан бөгөөд тус хуулиуд 2020 оны 01 дүгээр сарын 1-ний өдрөөс хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн.

⁶ Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль (2019)

- Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн дагуу ашигт магтмалын тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээд нь аливаа татварын хөнгөлөлт болон чөлөөлөлтийг эдлэхгүй;
- Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн дагуу экспортод гаргасан ашигт магтмалын эцсийн бүтээгдэхүүнд НӨАТ-ийг “0” хувиар ногдуулдаг. Харин экспортод гаргасан эцсийн бүтээгдэхүүнээс бусад ашигт магтмалын бүтээгдэхүүнийг НӨАТ-аас чөлөөлдөг.

5. Хөрөнгө оруулалт болон Санхүүжилт

5.1 Хөрөнгө оруулалт татах

Монгол Улс хөрөнгө оруулагчийг татах идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг бөгөөд хөрөнгө оруулалт холбоотой харилцааг 2013 оны 10 дугаар сарын 13 өдөр батлагдсан Хөрөнгө оруулалтын тухай хуулиар зохицуулсан байдаг.

А. Тогтворжуулах гэрчилгээ

Хөрөнгө оруулалтыг татах зорилгоор Хөрөнгө оруулалтын тухай хуульд заасан шалгуурыг бүрэн хангасан хөрөнгө оруулагч хуулийн этгээдийн төлөх татварын хувь, хэмжээг тогтворжуулах зорилгоор Төрийн Захиргааны байгууллага тогтворжуулах гэрчилгээ олгодог. Тогтворжуулах гэрчилгээ нь олгосон өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болох бөгөөд уг гэрчилгээний хүчинтэй байх хугацаанд татварын хувь, хэмжээг тогтворжуулна. Тогтворжуулах гэрчилгээ уул уурхайн олборлолт, хүнд үйлдвэр, дэд бүтцийн салбарт дараах хугацаагаар олгогдоно:

Хөрөнгө оруулалтын хэмжээ /тэрбум төгрөгөөр/	Тогтворжуулах гэрчилгээ олгох хугацаа /жилээр/					Хөрөнгө оруулалтаа хийж дуусах хугацаа /жилээр/
	Улаанбаатарын бүс	Төвийн бүс	Хангайн бүс	Зүүн бүс	Баруун бүс	
30-100 хүртэл	5	6	6	7	8	2
100-300 хүртэл	8	9	9	10	11	3

300-500 хүртэл	10	11	11	12	13	4
500-аас дээш	15	16	16	17	18	5

Б. Хөрөнгө оруулалтын гэрээ

Засгийн газар 500 тэрбум төгрөг /Монгол банкны ханшаар 176,919,756 ам доллар/ - өөс дээш хэмжээний хөрөнгө оруулалт хийх хөрөнгө оруулагчтай үйл ажиллагаа явуулах орчныг нь тогтвортой байлгах зорилгоор Хөрөнгө оруулалтын гэрээ байгуулна. Хөрөнгө оруулалтын гэрээнд хөрөнгө оруулагчид үзүүлэх эрх зүйн баталгааг олгож, татварын орчныг тогтворжуулах, зохицуулалтын болон санхүүгийн дэмжлэг үзүүлэх нөхцөлүүдийг тусгаж болно⁷.

В. Хөрөнгө оруулагч болон түүний төлөөлөгч

Хөрөнгө оруулагчийн ажлын байр, татвар төлөлт, үйл ажиллагааны тогтворжилтыг харгалзан хөрөнгө оруулагчид оршин суух зөвшөөрлийг 1 жилийн хугацаатай олгох бөгөөд тухай бүр 3 жилийн хугацаатай сунгана⁸.

Гадаадын хөрөнгө оруулалттай хуулийн этгээдийн хөрөнгө оруулагч, гишүүн, удирдах бүрэлдэхүүний 3 хүртэлх төлөөлөгчийг хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын тодорхойлолтыг үндэслэн ажлын байрны төлбөрөөс чөлөөлдөг⁹.

Г. Хөрөнгө оруулагчийн эрх

Хөрөнгө оруулагч нь гадаад улсаас бараа, ажил, үйлчилгээ импортлох, үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээг экспортлох, хөрөнгөө захиран зарцуулах, хууль ёсны орлого, ашгийг гадаадад шилжүүлэх, гадаадаас шилжүүлж авах, санхүүжилт, зээл, тусламж, газар, байгалийн баялгийг ашиглах хүсэлт гаргах, хүсэлтээ шийдвэрлүүлэх эрхтэй.

⁷ Хөрөнгө оруулалтын тухай хууль (2013)

⁸ Засгийн газрын 2018 оны 146 дугаар тогтоолоор батлагдсан Гадаадын иргэн Монгол улсад оршин суух болон түүнийг бүртгэх журам

⁹ Засгийн газрын 2015 оны 41 дүгээр тогтоолоор баталсан Ажлын байрны төлбөр авах, хөнгөлөлт үзүүлэх, чөлөөлөх журам

5.2 Гадаадын хөрөнгө оруулалтыг хязгаарлах тухай

Уул уурхай салбарт үйл ажиллагаа эрхлэх Монгол Улсын хуулийн этгээдийн нийт гаргасан хувьцааны 33 буюу түүнээс дээш хувийг гадаадын төрийн өмчит хуулийн этгээд эзэмших тохиолдолд эрх бүхий байгууллагаас зөвшөөрөл авдаг. Үүнээс өөрөөр ашигт магтмалын үйл ажиллагаа явуулахад гадаадын хөрөнгө оруулагчид тавих ямарваа хязгаарлалт, хориг байхгүй.

5.3 Олон улсын гэрээ, хэлэлцээр

Монгол Улс уул уурхайн салбарт хэд хэдэн олон улсын гэрээ, хэлэлцээрийн тал болдог. Жишээлбэл: Олон талын хөрөнгө оруулалтыг баталгаажуулах байгууллагын конвенц /1998/, Монгол Улсын Засгийн газар, Олон Улсын Хөгжлийн Ассоциаци хооронд 2011 оны 5 дугаар сарын 24-ний өдөр байгуулсан “Уул уурхайн дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг дэмжих төсөл”-ийн санхүүжилтийн хэлэлцээр, Хөрөнгө оруулалтыг хөхүүлэн дэмжих, харилцан хамгаалах тухай 2 талт гэрээнүүдийг 42 улстай байгуулсан.

Түүнчлэн Монгол Улс болон бусад улсын иргэдийн хооронд хөрөнгө оруулалтын талаар үүссэн маргааныг шийдвэрлэх тухай конвенц болон Гадаадын арбитрын байгууллагын шийдвэрийг хүлээн зөвшөөрөх ба биелүүлэх тухай конвенцийг соёрхон баталсан.

5.4 Санхүүжилтийн эх үүсвэр

Тусгай зөвшөөрөлтэй компаниуд зарим тохиолдолд өөрийн үндсэн хөрөнгөөс гадна бусад санхүүгийн боломжийг эрэлхийлдэг.

Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь санхүүжилт олох, хөрөнгө оруулалтын асуудлыг шийдвэрлэхийн тулд тусгай зөвшөөрлийг банк, банк бус санхүүгийн байгууллагад эсхүл татварын албанд барьцаалж болдог. Тусгай зөвшөөрөл нь дангаараа барьцааны зүйл болохгүй.

Тусгай зөвшөөрөл эзэмшигч этгээд бусад хуулийн этгээдтэй нэгдэх, нийлэх хэлбэрээр өөрчлөн байгуулагдаж үйл ажиллагаа явуулж болдог.

5.5 Тусгай зөвшөөрөл шилжүүлэх

Тусгай зөвшөөрөл эзэмшигч холбогдох хууль тогтоомжийн дагуу худалдаж зохих албан

татвар төлсөн нь баримтаар нотлогдсон тохиолдолд түүний эзэмшилд байсан тусгай зөвшөөрлийг худалдан авагчид нь шилжүүлж болно. Хэрэв Компани хуваагдах эсхүл тусгаарлагдах замаар өөрчлөн байгуулагдсан тохиолдолд уг тусгай зөвшөөрлийг Төрийн Захиргааны Байгууллагад буцааж өгөх үүрэг хүлээдэг.

Хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь олгогдсон талбайн тодорхой хэсгийг тусгай зөвшөөрөл эзэмших эрх бүхий бусад этгээдэд шилжүүлж болох бөгөөд шилжүүлсэн болон үлдэх талбайн хэмжээ, хэлбэр, байршил нь мөн хуульд заасан нөхцөл, шаардлагыг хангасан байна.

6. Дүгнэлт

Монгол Улс ашигт магтмалын нөөц ихтэй орнуудын нэг бөгөөд уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулж байгаа хуулийн этгээдийн тогтвортой байдлыг дэмжих, хөрөнгө оруулагч нарыг татах хууль, эрх зүйн таатай орчныг бүрдүүлсэн.

АМТХ-ийн зааснаар Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу үүсэн байгуулагдсан татвар төлөгч хуулийн этгээд хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийг эзэмших эрхтэй байдаг.

Хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийг хуульд заасан журмын дагуу сонгон шалгаруулалтын зарчмаар олгодог бөгөөд хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь хайгуулын талбайн тодорхой хэсэг эсхүл бүхэлд нь ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмших онцгой эрхтэй.

Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь АМТХ-д заасны дагуу эрх эдэлж үүрэг хүлээх бөгөөд нэмэлтээр хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлөө барьцаалах эсхүл шилжүүлэх боломжтой. Түүнчлэн хайгуул болон ашиглалтын үйл ажиллагаа эрхлэхдээ байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, хүн амын эрүүл мэндийг хамгаалах, ашигт магтмал ашигласны төлбөр төлөх үүрэг хүлээдэг.

Хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээд нь аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн дагуу 6 тэрбум төгрөг хүртэлх татвар ногдуулах орлого 10 хувийн татвар, 6 тэрбумаас дээш төгрөгийн орлогод 25 хувийн татвар төлдөг. Харин Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн дагуу хөнгөлөлт, чөлөөлөлт эдлэх боломжтой.

Хөрөнгө оруулагч нарын хувьд татварын хувь хэмжээг тогтворжуулах зорилгоор

тогтворжуулах гэрчилгээ болон 500 тэрбум төгрөгөөс Монгол банкны ханшаар 176,919,756 ам доллар) дээш хэмжээний хөрөнгө оруулалт хийсэн тохиолдолд үйл ажиллагааг нь тогтвортой явуулах зорилготой Хөрөнгө оруулалтын гэрээ байгуулдаг. Нэмэлтээр удирдах албан тушаалтан нь удаан хугацааны оршин суух зөвшөөрөл, виз авах болон ажлын байрны төлбөрөөс чөлөөлөгдөх боломжтой.

Дэлхийн 20 улсад салбартай олон улсын хуулийн фирм Грата Интернэшнлийн Монгол дах оффис болох Өмгөөллийн “Абсолют Адвокатс” ХХН энэхүү хууль зүйн мэдээллийг бэлтгэсэн. Энэхүү хуулийн зүйн мэдээлэл нь ерөнхий мэдээлэл өгөх зорилготой бөгөөд тодорхой асуудалд нарийвчлан дүн шинжилгээ хийгээгүй болно. Энэхүү хууль зүйн мэдээллийг уншигч нь ямар нэгэн үйлдэл хийхээсээ өмнө өөрсдийн нөхцөл байдалд тохирсон мэргэжлийн зөвлөгөө авах хэрэгтэй. Энэхүү хууль зүйн мэдээллийг ашигласны улмаас үүссэн аливаа үр дагавар, хохирлыг бид хариуцахгүй.